

НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛСЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРИМ ТӨРӨЛ

Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ

1. Орлогын албан татвар
2. Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар
3. Цалингийн татвар
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар
5. Монгол Улс, Нидерландын Вант улс хоорондын гэрээ

* * *

Оршил

УИХ-ын гишүүн Д.Ганхуягийн захиалгаар “Нидерландын Вант улсын татварын зарим төрөл” сэдэвт лавлагаа-мэдээллийг хийж гүйцэтгэв. Лавлагаа-мэдээлэлд Нидерландын Вант улсын орлогын дараах төрлийн албан татваруудыг хамруулсан:

- Орлогын албан татвар,
- Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар,
- Цалингийн татвар,
- Нэмэгдсэн өртгийн албан татвар.

Албан татварын төрлүүдийг дараах дэд сэдвээр задлаж оруулсан:

- Албан татвар төлөгч,
- Албан татвар ногдох орлого,
- Албан татварын хувь хэмжээ,
- Албан татварын хөнгөлөлт,

2002 оны 3 дугаар сарын 8-нд Монгол Улс, Нидерландийн Вант Улсын Засгийн газар хооронд Орлогын албан татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай конвенцийг байгуулсан ба уг конвенцийн тухай 5 -р хэсэгт оруулсан.

1. Орлогын албан татвар**1.1. Албан татвар төлөгч**

Орлогын албан татвар нь хувь хүний орлогод ногдуулах татвар бөгөөд татвар төлөгч нь Нидерландын Вант улсад байнга оршин суудаг хувь хүн (байнга оршин суугч), Нидерландын Вант улсад байнга оршин суудаггүй боловч тус улсад орлого олдог хувь хүн (түр оршин суугч) хамаарна.

Байнга оршин суугчийн орлогын эх үүсвэрээс нь үл хамааран бүх орлогод албан татвар ногдуулна. Өөрөөр хэлбэр, Нидерландын нутаг дэвсгэр болон түүний гадна олсон бүх орлогыг ойлгоно. Харин түр оршин суугчийн гагцхүү Нидерландын улсын нутаг дэвсгэрт шууд холбоотой эх үүсвэрээс олсон орлогод албан татвар ногдуулна.

1.2. Албан татвар ногдох орлого

Тус улсын хувь хүний орлогын албан татвар 2001 оны 1 дүгээр сарын 1-ээс гурван төрөл /хайрцаг/ болж ангилагдсан байна:

- Хайрцаг 1 – Ажил болон орон байрны орлогод ногдуулах албан татвар,
- Хайрцаг 2 – Бодит ашгийн орлогод ногдуулах албан татвар,
- Хайрцаг 3 – Хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод ногдуулах албан татвар.

1.2.1. Ажил болон орон байрны орлогод ногдуулах албан татвар

Хайрцаг 1 буюу ажил болон орон байрны дараах орлогод албан татвар ногдуулна:

- Бизнес болон мэргэжлийн үйл ажиллагаанаас олсон орлого;
- Цалингийн орлого;
- Бусад үйл ажиллагаанаас олсон орлого;
- Тогтмол төлбөр болон тэтгэлэг (Засгийн газрын тусламж, амьжиргааны тэтгэмж гм.);
- Орон сууцнаас олсон орлого;
- Орлогын бүрдүүлэлт дэх зарцуулалт (тэтгэвэр, тэтгэмжийн урамшуулал, асран хамгаалагчдад олгох тэтгэмж гм.);
- Орлогын бүрдүүлэлтийн зарцуулалтыг хасах (орлогоос нь урьдчилан суутгасан тэтгэвэр, тэтгэмжийн урамшуулал гм.);
- Хувь хүний суутгалыг хасах (хувь хүнээс өмнөх жилд суутгасан төлбөрийг буцаан төлөх гм.)
- Хувийн суутгал (энэхүү суутгал нь хэсэгчлэн 3 -р Хайрцаг руу шилжиж болох ба үүнийхээ дараа 2-р Хайрцаг руу шилжих боломжтой).

1.2.2. Бодит ашгийн орлогод ногдуулах албан татвар

Байнга оршин суугч-татвар төлөгч нь өөрөө дангаараа, эсхүл хамтрагчтайгаа шууд, эсхүл шууд бусаар компанийн хамгийн багадаа 5 хувийн хувьцааг эзэмшдэг, компаниас бодит ашиг авдаг бол татвар төлөгчид тооцогдоно. Бодит ашгийн орлого нь зардалаа хассан ногдол ашгийн нийт дүн болон худалдааны орлого юм.

Түр оршин суугчийн хувьд компани нь Нидерланд улсад сүүлийн арван жилд хамгийн багадаа 5 жил байнга оршиж байсан бол мөн тус улсын байнгын татвар төлөгчид тооцогдоно.

1.2.3. Хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод ногдуулах албан татвар

Энэ төрлийн орлого нь бодит орлогоос хамааралгүй гагцхүү цэвэр хөрөнгөөс хийгдсэн тохиолдолд хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогын татварын суурь болно. Цэвэр хөрөнгө нь хуанлийн жилийн (1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31) дунджаар үнэлэгдэнэ.

Хайрцаг 3 -т хамаарах албан татвар ногдох орлогын зарим жишээ:

- хадгаламж,
- хоёр дахь орон байр, эсхүл зөвшөөрөгдсөн хөрөнгө,
- хувьцаа болон бусад үнэт цаас,

- даатгалын тэтгэмж,
- хэрэглэгчийн зээл,
- Хайрцаг 1, эсвэл Хайрцаг 2-т хамааралгүй өр.

Түр оршин суугчийн зөвхөн Нидерланд улс дахь хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод татвар ногдуулна.

Хайрцаг 3-т дараах орлого хамаарахгүй:

- эзэмшигчийн эзэмшилд байгаа орон байр (Хайрцаг 1-д хамааралтай) болон орон байртай хамааралтай хандивийн даатгал,
- ахуйн хэрэглэл, хөнгөн автомашин, чиргүүл зэрэг хувийн хэрэгцээний эдлэл,
- хөрөнгө оруулах зорилгогүйгээр хадгалсан урлагийн болон шинжлэх ухааны бүтээл,

1.3. Албан татварын хувь хэмжээ

Хайрцаг 1 – Ажил болон орон байрны орлогод ногдуулах албан татвар

- Ангилал 1: эхний 18,218 €-ны орлогод 33.45 хувийн татвар (33.45 хувийн татвар нь 2.3 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 2: дараагийн 14,520 € -ний орлогод 41.95 хувийн татвар (41.95 хувийн татвар нь 10.8 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 3: дараагийн 21,629 €-ний орлогод 42 хувийн татвар.
- Ангилал 4: үлдэгдэл орлогод 52 хувийн татвар.

Эхний 2 ангилалд орлогын хэмжээ бага, мөн түүнчлэн 65 болон түүнээс дээш насныханд хамаарна.

Хайрцаг 2 – Бодит ашгийн орлогод ногдох албан татварын хувь хэмжээ тогтмол 25 хувь байна.

Хайрцаг 3 – Хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод ногдох албан татварын хувь хэмжээ тогтмол 30 хувь байна.

1.3. Албан татварын хөнгөлөлт

Зөвхөн голландын нийгмийн хамгаалалд орсон ажилтан нь татварын хөнгөлөлтийг авах эрхтэй. Мөн түүнчлэн татвар төлөгчийн орлогын хэмжээ болон хувийн нөхцөл байдлыг харгалзан бусад нэмэлт хөнгөлөлтийг үзүүлнэ.

Байнгын оршин суугчийн татварын хэмжээ урамшууллалын дүнгээр багасна. Ерөнхий урамшуулалыг бүх байнгын оршин суугч татвар төлөгчдөд хамааралтай бөгөөд татварын элемент ба нийгмийн хамгаалалтын хандивийн элементийг бүрдүүлнэ.

Хайрцаг 3 -т татвар төлөгч 20,014 €-д татвараас чөлөөлөгдөх эрхтэй. Татвараас чөлөөлөгдөх энэ хэмжээ нь татвар төлөгчийн 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар асран хамгаалж буй 18 нас хүртэлх хүүхэд бүрд 2,674 €-гоор нэмэгдэнэ. Иргэдийн орлого, баялагаас хамаарч 65 ба түүнээс дээш насны татвар төлөгчийн татвараас чөлөөлөгдөх хэмжээг дээд тал нь 26,494 € хүртэл нэмэх эрхтэй.

1.4. Орлогын албан татварын буцаан олголт

Тухайн санхүүгийн жилийн татварын тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний

дотор Татварын Удирдах газарт мэдүүлсэн байх ёстой. Хэрэв Татварын Удирдах газар заасан хугацаанд тайланг хүлээж аваагүй бол холбогдох байгууллагад сануулга өгөх, эсхүл торгууль ногдуулах хүртэл арга хэмжээ авна. Татварын Удирдах газарт тайланг хойшлуулах тухай бичгээр хандаж болно. 4 дүгээр сарын 1-ний дотор татвар буцаан авахаар бүртгүүлсэн хүн бүр 7 дугаар сарын 1-ний дотор Татварын албанаас мэдэгдэл хүлээн авна.

2. Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар

2.1. Албан татвар төлөгч

Аж ахуй нэгж байгууллагын албан татварын тухай хуульд зааснаар компанийг төрийн хязгаарлагдмал (NV⁸²) ба хувийн хязгаарлагдмал (BV⁸³) гэж ангилна. Нидерландын нутаг дэвсгэрт байгуулагдсан компани нь байнгын татвар төлөгч байна. Нидерландын нутаг дэвсгэрт байгуулагдаагүй боловч тус улсын нутаг дэвсгэр дээр ашиг орлого олдог тодорхой компаниуд нь байнгын бус татвар төлөгч байна.

2.3. Албан татварын хувь хэмжээ

Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын хувь хэмжээ татвар ногдох орлогын эхний 200,000 €-нд 20 хувь, 200,000 € -ноос дээш орлогод 25.5 хувийн татвар тус тус ногдуулна. 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн патент ашиглан олсон орлогод 5 хүртэлх хувийн татвар ногдуулна.

2.4. Албан татварын хөнгөлөлт

Дотоодын болон гадаадын хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид татвараас чөлөөлөгдөнө. Хэрэв татвар төлөгч нь бүхлээрээ, эсхүл хэсэгчлэн хувьцаа болж тараагдаж номинал болон төлөгдсөн компанийн хөрөнгийн 5-аас багагүй хувийг эзэмшдэг бол үйл ажиллагааг нь харж үзнэ. Хэрэв охин компани нь захирагдах шаардлагыг дагах бол түүний пассивын 5 ба түүнээс дээш хувийн ашиг нь үйл ажиллагааг нь харна. Хэрэв татвар төлөгч, эсхүл түүний охин компани нь хөрөнгө оруулагч хуулийн этгээд бол татвараас чөлөөлөгдөхгүй. 5-аас илүүгүй хувийн ашгийг татвараас чөлөөлөх боломжгүй.

2.5. Албан татварын буцаан олголт

Төрийн (NV) ба хувийн (BV) хязгаарлагдмал хариуцлагатай компани нь санхүүгийн жил дууссанаас хойш 6 сарын дотор Татварын Удирдах газарт жилийн татварын тайланг электрон хэлбэрээр мэдүүлэх ёстой. Хэрэв буцаан олголт олгогдоогүй бол байцаагч урьдчилсан үнэлгээг гаргана. Эцсийн үнэлгээг тухайн санхүүгийн жилээс хойш 3 жилийн дотор гаргасан байх ёстой.

3. Цалингийн татвар

Нидерланд улсад ажил хийж цалин авдаг хүн бүр цалингийн татвар төлнө. Цалин олгож

⁸² Naamloze vennootschap (N.V., эсвэл NV гэж товчилно) – төрийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн голланд нэр томъёо. Компани нь хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байдаг, харин компанийн хувьцаа нь тодорхой эзэмшигчийн нэр дээр бүртгэлгүй учир нээлттэй хөрөнгийн зах зээлд борлогдох боломжтой.

⁸³ Besloten Vennootschap (BV гэж товчилно) – хувийн хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн голланд нэр томъёо. Компани нь хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байдаг, харин компанийн хувьцаа нь бүртгэгдсэн бөгөөд чөлөөтэй борлогдох боломжгүй.

буй ажил олгогч, эсхүл хуулийн этгээд нь цалингийн орлогын татвар төлөлтийг хойшлууж, Татварын Удирдах газарт тодорхой цаг хугацааны дараа төлж болно. Цалингийн татвар нь цалингийн орлогын татвар болон нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ. Нийгмийн хамгааллын хураамж нь өндөр настны тэтгэвэр (AOW), нас барагчийн ар гэрийхэнд нь олгох тэтгэмж (ANW) болон онцгой эмнэлгийн зардал (AWBZ) зэрэгт төлөгдөнө. Нидерланд улсад ажиллагсад нь нийгмийн хамгаалалд хамрагддаг учир нийгмийн хамгааллын хураамжийг төлөх үүрэгтэй.

3.1. Албан татвар төлөгч

Ажилагсад цалингийн татвар болон нийгмийн хамгааллын хураамжийг өөрийн ашиг орлогоос төлөх ёстой. Мэргэжлийн жүжигчид болон тамирчид ажил хийж байгаа, эсхүл хийгээгүйгээс үл хамааран цалингийн татварыг заавал төлөх ёстой. Ажил олгогч болон ажилтан хоёр хоёулаа Татварын Удирдах газарт мэдүүлгээ өгөх үүрэгтэй.

3.2. Албан татварын хувь хэмжээ

65 ба түүнээс дээш насны этгээдэд тусдаа буюу 1-р Ангилалын хувь хэмжээг ногдуулна. Энэхүү тусгайлсан хувь хэмжээ нь татвар төлөгч нь өндөр настны тэтгэврийг (AOW) заавал төлөх шаардлагагүй. Гэхдээ тэд Онцгой эмнэлгийн зардлын ерөнхий хууль (AWBZ) болон Тэтгэврийн тухай хууль (ANW)-д заасан 42 хувь болон 52 хувийн хураамжийг тус тус төлнө.

- Ангилал 1: эхний 18,218 €-ны орлогод 33.45 хувийн татвар (2.3 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 2: дараагийн 14,520 €-ний орлогод 41.95 хувийн татвар (10.8 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 3: дараагийн 21,629 €-ний орлогод 42 хувийн татвар.
- Ангилал 4: үлдэгдэл орлогод 52 хувийн татвар.

3.3. Татварын хөнгөлөлт

Хөнгөлөлтөнд ерөнхий хөнгөлөлт, хөдөлмөр эрхлэлтийн хөнгөлөлтөөс бүрдэнэ. Ерөнхий хөнгөлөлт нь бүх ажилагсдад хамаарах бөгөөд татвар болон нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ. Зөвхөн голландын нийгмийн хамгаалалд зайлшгүй орсон ажилтан нь ерөнхий хөнгөлөлтийг авах эрхтэй. Ажил олгогч нь ажилтны хувийн нөхцөл байдалтай холбоотой ямар ч хөнгөлөлт, чөлөөлтийг авахгүй.

3.4. Албан татварын буцаан олголт

Татвар төлөгч нь татвар буцан авах мэдүүлгийг Татварын Удирдах газарт өгөх ёстой. Татварын буцаан олголт бол цалингийн татварын, нийгмийн хамгааллын хураамж болон Эрүүлийн хамгаалахын тухай хуульд заасан даатгалын урамшуулал зэргийг багтаасан хосолсон татварын буцаан олголт юм.

4. Нэмэгдсэн өртгийн албан татвар

4.1. Албан татвар төлөгч

Бизнес эрхлэгч хувь хүн болон хуулийн этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна. Олон нийтийн бус салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагад мөн НӨАТ-ыг ногдуулна.

4.2. Албан татвар ногдох орлого

Нидерландын Вант улсад Европын нэмэгдсэн өртгийн албан татварын тухай 6 дугаар удирдамж /6th European VAT Directive/-д заасны дагуу үйлдвэрлэлийн шат дамжилга бүрт, бараа таваар хуваарилалт болон үйлчилгээнд НӨАТ-ыг ногдуулна.

Дараах үйл ажиллагаанууд нь НӨАТ ногдох орлого болно:

- Компаниар бараа нийлүүлэх,
- Компаниар үйлчилгээ хийлгэх,
- Компаниар Европын холбооны бусад гишүүн улсаас бараа олж авах,
- Барааны импорт,
- Хувь хүнээр Европын холбооны бусад гишүүн улсаас шинэ болон шинэвтэр тээврийн хэрэгсэл (автомашин, усан онгоц, нисэх онгоц) олж авах.

4.3. Албан татварын хувь хэмжээ

НӨАТ-ын ерөнхий хувь хэмжээ нь 19 хувь байна. 6 хувийн бууруулсан хувь хэмжээ нь импорт болон Хамтын нийгэмлэгийн дотор бараа, үйлчилгээ авах үйл ажиллагаа болно. Буруулсан хувь хэмжээнд хоол хүнсний бүтээгдэхүүн болон эмчилгээний эмийн бүтээгдэхүүн хамаарна.

Ус, урлаг, ном, сонин, сэтгүүл, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах багаж, хиймэл эрхтэн, газар тариалангийн зарим бараа, үйлчилгээ, зорчих тээвэр, спорт, хөдөлмөр шаардсан үйлчилгээ болон театр, жүжиг, музей, кинотеатр, спортын арга хэмжээ, хөгжөөнт тогтоомын парк, амьтаны хүрээлэн, циркийн орох тасалбар зэрэг бараа үйлчилгээнд ногдуулах татварын хэмжээ харьцангуй бага байна.

4.4. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Дараах бараа, үйлчилгээнд 0 хувийн татвар ногдуулна:

- Европын холбооны улсуудаас оруулж ирсэн бараанууд,
- Олон улс хооронд хэрэглэх усан онгоц болон нисэх онгоц,
- Төв банкны алт.

Түүнчлэн Европын холбооны бусад гишүүн орон руу бараа тээвэрлэхэд НӨАТ ногдуулахгүй. Зарим төрлийн хэлцэл НӨАТ-аас чөлөөлөгдөнө. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгө зарим шилжүүлэлт, түрээс,
- Эмнэлгийн үйлчилгээ,
- Боловсролын байгууллагын үйлчилгээ,
- Нийгэм-соёлын үйлчилгээ,
- Ихэнхи банкны үйлчилгээ,
- Даатгалын хэлцэл,
- Олон нийтийн мэдээллийн байгууллагын арилжааны бус үйл ажиллагаа,
- Зарим шуудангийн үйлчилгээ,
- Оршуулга болон чандарлах,
- Спортын байгууллагын өөрийн гишүүдэд зориулагдсан үйлчилгээ (тоглолтын тасалбарт хамаарахгүй),
- Хөгжмийн зохиолч, зохиолч, сэтгүүлчдийн үзүүлж байдаг үйлчилгээ,

- Гэрийн арчилгааны үйлчилгээ.

4.4. Албан татварын буцаан олголт

Татвар төлөгч НӨАТ-ын мэдүүлгийн маягтыг заавал бөглөж өгнө. Татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтоо сар бүр, улирал бүр, жил бүр авах эсэхээ өөрөө тогтоох боломжтой. Татварын удирдах газар мэдүүлгийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор буцаан олголтыг шалгаж шийдвэрлэнэ. Татвар төлөгч нь мэдүүлгийн маягтыг хугацаанаас нь хоцроосон тохиолдолд торгууль ногдуулна.

5. Монгол Улс, Нидерландын Вант улс хоорондын конвенц

Нидерландын Вант улс нь орлогын татварыг давхардуулан ногдуулахгүй байх гэрээг дэлхийн олон улс оронтой байгуулсан. 2007 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар тус улс дэлхийн 77 улстай гэрээ, конвенц байгуулсан байна. Үүнд, Монгол Улс багтаж байгаа бөгөөд орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх зорилготойгоор Монгол Улсын Засгийн газар ба Нидерландын Вант улсын Засгийн газрын хооронд хэлэлцэн тохиролцож уг конвенцийг 2002 оны 3 дугаар сарын 8-ны байгуулсан.

Энэхүү конвенц нь хэлэлцэн тохирогч хоёр улсын нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдэд хамаарна. Конвенцид дараах төрлийн орлогын татваруудыг давхардуулахгүй байхаар заасан байна. Үүнд: Монголын хувьд – хүн амын орлогын албан татвар, аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар, Нидерландын хувьд – орлогын татвар, цалингийн татвар, компанийн татвар, ногдол ашгийн татвар орсон байна.

Конвенцийн бүтцийг авч үзвэл 5 бүлэг, 33 зүйлтэй. Монгол Улс, Нидерландын Вант улсын хоорондын Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай конвенцид гарын үсэг зурах үед 16 заалттай Протоколд мөн гарын үсэг зурсан бөгөөд уг Протокол нь Конвенцийн салшгүй хэсэг болсон.

Уг конвенцийн заалтыг ашиглан гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Нидерланд улсад толгой компаниа бүртгүүлэн, тус улсаар дамжуулан Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, улмаар татвараас зайлсхийх явдал гарах болсон. Иймд Монгол Улсын Сангийн яам Нидерландын Вант улстай байгуулсан давхар татварын гэрээнд өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа аж. Яамны зүгээс гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлтийг нөгөө тал буюу Нидерландын Вант улсад тавьсан бөгөөд хэрэв өөрчлөлт оруулах саналыг хүлээн авахгүй бол гэрээний эрхийнхээ дагуу Монгол Улс дангаар цуцлах болно гэдгээ мэдэгдсэн тухай холбогдох албаныхан мэдэгдэж байна.

Ашигласан материалын жагсаалт

- <http://english.minfin.nl/Subjects/Taxation>
- Татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай Монгол Улсын Олон улсын хэлэлцээрүд. Боть 2. Эмхтгэсэн Я.Пүрэвэ. УБ хот., 2011 он.

